



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/38

Улаанбаатар хот

Дүүргийн малчин болон мал бүхий иргэдэд өвс, тэжээлийн дэмжлэг олгох ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2022 оны 277 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/1192 дугаар захирамжийн үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэр цас ихтэй, хаваржилт хүндэрч малын зүй бус хорогдол эхэлж байгаатай холбогдуулан дүүргийн 2022-2023 оны хөдөө аж ахуйн аюулгүй нөөцөд байгаа 800 боодол өвс, Монгол улсын шадар сайд С.Амарсайханы дэмжлэгээр олгосон 40тн малын тэжээл, 10 тн эрдсийг малчдад хүргэх ажлыг зохион байгуулахыг Засаг даргын зөвлөх (Г.Дагвадорж)-д үүрэг болгосугай.

2. Тус ажилд зарцуулагдах 602,500 (зургаан зуун хоёр мянга таван зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3. Малчдад өвс тэжээл хүргэх авто машины бэлтгэл, аюул осолгүй байдлыг хангахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, танилцуулахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

АЖИЛ/2023 он ажил/захирамж

1123000114

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 02 сарын 22-ны өдрийн 1138 дугаар
захирамжийн хавсралт



ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Бүгд үнэ
1	Бинзен шатахуун тээвэрлэлт (1000км)	л	250	2,410	602,500